Сайн шалга!

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ!

Хөдөлмөр эрхлэгч ч, ажил олгогч ч
шалгахаа мартуузай.

Коочи мужийн Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

2025 оны
12 сарын
1 өдрөөс
Цагийн үнэлгээ

1,023 иен

Өмнөх жилээс UP
71 иен

モンゴル語版

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг нь хөдөлмөр эрхэлж буй бүх хүнд цалингийн хамгийн бага үнэлгээг баталгаажуулж буй тогтолцоо юм.

WEB-р шалга!
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх тусгай вебсайт
(Зөвхөн Япон хэл дээр)
最低賃金　特設サイト　検索

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар лавлах бол Коочигийн Хөдөлмөрийн товчоо эсвэл ойролцоох Хөдөлмөрийн стандартын хяналтын газарт хандана уу.
高知労働局　検索

Хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэх тухай тусгай хуудас
(Зөвхөн Япон хэл дээр)
Хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэгийн бодлогыг нийтэлсэн.
賃金引上げ特設ページ　検索

Жижиг дунд бизнес эрхлэгч та бүхэнд

業務改善助成金
6 сая хүртэл иенийн дэмжлэг үзүүлнэ

Эрүүл мэнд, Хөдөлмөр,
Нийгмийн Хамгаллын Яам

Хөдөлмөр эрхлэгч ч, ажил олгогч ч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг заавал шалга!

"Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тогтолцоо" нь нас болон цагийн ажилтан, оюутан зэргээс үл хамааран хөдөлмөр эрхэлж буй бүх хүнд тэгш үйлчилнэ. Шалгахыг хүсэж буй хөдөлмөрийн хөлс (*1) болон ажиллаж байгаа хот, мужийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн үнэлгээ)-г хүснэгтэд бөглөж бичин, харьцуулж үзээрэй! (*2)

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг харьцуулах арга

Өөрийн цалин болон харьяа хот, мужийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний үнэлгээг бичиж үзээрэй. (*2)

A Цагийн цалинтай хүн

Цагийн цалин		Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн үнэлгээ)
иен	≧	иен

B Өдрийн цалинтай хүн

Өдрийн цалин		1 өдрийн ажлын дундаж цаг		Цагийн үнэлгээ		Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн үнэлгээ)
иен	÷	цаг	=	иен	≧	иен

C Сарын цалинтай хүн

Сарын цалин		1 сарын ажлын дундаж цаг		Цагийн үнэлгээ		Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн үнэлгээ)
иен	÷	цаг	=	иен	≧	иен

D Дээрх A, B, C-н холимог хүн

Жишээ нь үндсэн цалин нь өдрийн цалингаар бөгөөд нэмэгдлүүд (Ажлын байрны нэмэгдэл зэрэг) нь сарын цалин байдаг бол

① Үндсэн цалин (Өдрийн цалин) → B-ийн тооцооллоор цагийн үнэлгээг бодож гаргана.
② Нэмэгдэл хөлс (Сарын цалин) → C-ийн тооцооллоор цагийн үнэлгээг бодож гаргана.
③ ①болон ②-ийг нэмсэн дүн ≧ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (Цагийн үнэлгээ)

(*1) Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулахад дараах хөлсийг оролцуулж тооцохгүй.
① Нэмэгдэл хөлс (Гэрлэлтийн нэмэгдэл г.м) ② Нэг сарын хугацаа өнгөрөх тутамд олгох нэмэгдэл хөлс (Урамшуулал г.м.) ③ Тогтоосон ажлын цаг хэтэрсэн тохиолдолд олгогдох хөлс (Илүү цагийн нэмэгдэл г.м) ④ Тогтоосон ажлын өдрөөс гадна ажилласан өдрийн олгогдох хөлс (Амралтын өдрийн нэмэгдэл хөлс г.м) ⑤ Оройн 22 цагаас өглөө 5 цаг хүртэлх ажлын цагт олгогдох хөлсөд, өдрийн ажлын цагийн тооцсон үнэлгээнээс илүү гарсан дүн (Шөнийн цагийн нэмэгдэл г.м) ⑥ Ажил таслаж, хоцроогүйн нэмэгдэл, унаашы нэмэгдэл болон гэр бүлийн нэмэгдэл
(*2) Дэлгэрэнгүй тооцоолол хийх арга болон ажил гүйцэтгэлийн цалин олгох үеийн тооцоолох арга зэргийг Хөдөлмөрийн товчоо болон өөрт ойр Хөдөлмөрийн стандарт хяналтын газраас лавлана уу.

業務改善助成金

6 сая хүртэл иенийн дэмжлэг үзүүлнэ

Жижиг дунд бизнес эрхлэгч та бүхэнд!

Хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэхийг дэмжих "Бизнесийн үйл ажиллагааг сайжруулах дэмжлэг"-ийг идэвхтэй ашиглая!

Бизнесийн үйл ажиллагааг сайжруулах дэмжлэг гэдэг нь?

"Бизнесийн үйл ажиллагааг сайжруулах дэмжлэг" нь бүтээмжийг нэмэгдүүлэн "Ажлын байр доторх хамгийн бага хөдөлмөрийн хөлс (ажлын байран дахь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ)"-г нэмэгдүүлэх жижиг дунд аж ахуйн нэгж, бичил бизнес эрхлэгчийг дэмжих тэтгэмж юм.
Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт зэргийг хийсэн тохиолдолд олгох нөхцөлөөс хамааран тухайн зардлын тодорхой хувийг нөхөн олгоно.

Бизнесийн үйл ажиллагааг сайжруулах дэмжлэгийн дуудлагын төв

0120-366-440

Дэлгэрэнгүйг эндээс харна уу. (Зөвхөн Япон хэл дээр)

業務改善助成金 検索

Олгох нөхцөл

- Ажлын байр доторх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх
- Нэмэгдүүлсний дараах хөдөлмөрийн хөлс олгох
- Үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулахад тусгай тоног төхөөрөмж зэргийг нэвтрүүлэх
- Ажлаас чөлөөлсөн, хөдөлмөрийн хөлсийг бууруулсан зэрэг олголтод үл нийцэх хүчин зүйл байхгүй.

Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад зарцуулсан зардлын зарим хэсгийг нөхөн олгох.

Танилцуулгыг видеогоор үзээрэй!

Дэмжлэгийг олгох хүртэлх үйл явц

1. Олгохыг хүссэн өргөдөл, бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг ажлын байр нь байгаа орон нутгийн Хөдөлмөрийн газарт мэдүүлнэ.
2. Олгохоор шийдвэрлэсний дараа хүргүүлсэн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах. (Хяналт шалгалт)
3. Хэрэгжүүлсэн үр дүнгийн тайлан, олгохыг хүссэн өргөдлийг Хөдөлмөрийн газарт мэдүүлэх. (Хяналт шалгалт)
4. Цалинг олгох

Бүрдүүлэлтийг видеогоор үзээрэй!

Мэргэжилтнээс үнэ төлбөргүй зөвлөгөө авах

Хөдөлмөрийн хөлс нэмэгдүүлэлттэй холбоотой ямар нэгэн асуудал байвал Хөдөлмөрийн нөхцөл байдал сайжруулалтыг дэмжих төвд ирж зөвлөгөө авна уу.

Дэлгэрэнгүйг эндээс харна уу. (Зөвхөн Япон хэл дээр) 働き方改革推進支援センター 検索

Хөдөлмөрийн нөхцөл байдал сайжруулалтын дэмжих сан

Японы Засгийн Газрын Санхүүгийн корпороци нь ажлын байр доторх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг бизнес эрхлэгчид тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг хийдэг.

Дэлгэрэнгүйг эндээс харна уу. (Зөвхөн Япон хэл дээр) 働き方改革推進支援資金 検索

リサイクル適性Ⓐ
この印刷物は、印刷用の紙へリサイクルできます。

(R7.9)